

# “ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 19 ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

## Зардал урьдчилан гаргахыг зөвшөөрөх тухай


Компанийн тухай хуулийн 80.4, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 2.15, гүйцэтгэх захирлын хөлсөөр ажиллах гэрээний 3.6.2, 3.7 дахь заалтуудыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Диспетчерийн удирдлага, хяналт, мэдээллийн СКАДА системийн тоног төхөөрөмжийн тэжээлийн тасралтгүй ажиллагааг хангадаг UPS систем гэмтэж найдвартай ажиллагаа алдагдсан тул нэн шаардлагатай 26 700 000 төгрөгийн зардлыг урьдчилж гаргахыг Гүйцэтгэх захирал /Д.Балдорж/-д зөвшөөрсүгэй.

2. Дээрхи зардлыг 2017 оны сүүлийн хагас жилд багтаан компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгон тусгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Балдорж/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ГИШҮҮД



Д.ЧИМЭДДОРЖ

Н.УУГАНЧИМЭГ

Н.ХҮРЭЛЧУЛУУН

Н.ЦЭРЭНСАМБУУ

Д.ДАРИЙМАА

Х.ЭНХЖАРГАЛ

Ч.МАНГАЛЖАЛАВ